



**АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
1-Р УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, МЭДЭЭ ТАЙЛАН**

2017 ОН

АГУУЛГА

1. Улирлын үйл явдал
2. Эхний улирлын төлөвлөгөөний хэрэгжилт
3. Гүйцэтгэлийн аудитын хэрэгжилт
4. Нийцлийн аудитын хэрэгжилт
5. Санхүүгийн аудитын хэрэгжилт
6. Бусад ажил үйлчилгээний хэрэгжилтийн талаар

1. Улирлын үйл явдал

- Улсын ИХ Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу Аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/04 дугаар тушаалаар “ Аймгийн Аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө” г боловсруулан батлууллаа.
- Архангай аймгийн Аудитын газар 2017 онд “Аймгийн ИТХ-д хуулиар ноогдсон үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдал, хууль тогтоомжийн нийцэл, төсөв санхүүгийн үнэн зөв байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх “ гэсэн зорилгыг дэвшүүлсэн.
- Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг хангаж ажиллахаар төлөвлөөд байна.
 - Төрийн аудитын байгууллага чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх
 - Төрийн аудитын байгууллагад мөрдөж байгаа аудитын арга зүйг боловсронгуй болгох
 - Ажилчдын нийгмийн асуудлыг бодиттой шийдвэрлэх
 - Гадаад, дотоод түншлэлийг бий болгох, харилцагч талуудтай ажиллах тогтолцооны үр нөлөөг сайжруулах
- Архангай аймгийн Аудитын газар тайлант жилийн эхний улиралд 11 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирлээ.
- 2016 оны ажлаа дүгнэж, аудитын чанарт анхаарах үүднээс багуудад ажиллаж байгаа аудитор шинжээчдийг баг хооронд сэлгэх зохион байгуулалтын өөрчлөлт хийж нийцлийн аудитын баг шинэ бүрэлдхүүнтэйгээр ажиллахаар боллоо.
- 2017 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэл, нийцлийн 3 аудитыг эхлүүлэн аудитыг төлөвлөгдсөн хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.
- Санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуулийн хугацаанд СТАУС программаар бүрэн хийж дуусгаад байна.
- Төлөвлөгөөний бусад ажил үйлчилгээний дагуу хийх 12 ажил үйлчилгээний хэрэгжилт 75% -ийн гүйцэтгэлтэй байна.

2. Эхний улиралд хийгдэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт

Аймгийн Аудитын газрын 2017 оны эхний улирлын төлөвлөгөөгөөр хийгдэх ажлууд, тэдгээрийн биелэлтийн байдал

Хийгдэх ажлын нэр	хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа	Биелэлтийн хувь
1. 2017 оны 1-р улиралд хийгдэх аудитын төлөвлөгөө			
1. 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүн, үр ашиг	2017.03.01-2017.04.14	2017.03.01-2017.04.14	100%
2. Засгийн газраас олгосон векселийн үр дүн	2017.03.01-2017.04.14	2017.03.01-2017.04.14	100%
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтанд хийх нийцлийн аудит	2017.03.01-2017.05.01	2017.03.01-2017.05.01	100%
4. Газрын тухай хуулийн хэрэгжилтэд хийх нийцлийн аудит	2016.11.23-2017.04.01	2017.03.25-2017.04.25	100%
5. Төсвийн шууд захирагчдын / 196-н / жилийн төсвийн гүйцэтгэл, СТА	2017.01.25-2017.02.25	2017.01.25-2017.02.25	100%
6. Төсвийн төвлөрүүлэн захирагчдын / 19 / жилийн төсвийн гүйцэтгэл, СТА	2017.03.05-2017.03.25	2017.03.05-2017.03.25	100%
2. Бусад ажил үйлчилгээний төлөвлөгөө			
1. ААГ-ын МТС-ын 2017 оны хөтөлбөр, төлөвлөгөө батлуулах	2017.03.25	2017.04.02	100%
2. ААГ-ын 2017 оны 1-р улирлын статистик мэдээ, тайлан гаргах	2017.03.30	2017.04.15	100%
3. Байгууллагын ажилтнуудтай 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулах	2017.03.30	2017.03.17	100%
4. ТАБ-ын албан тушаалтны ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэгийг нэгтгэн УАГ-т хүргүүлэх	2017.02.15	2017.02.15	100%
5. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	2017.03.01	2017.03.01	100%
6. Аудитын дүнгийн талаар ил тод байдлыг хангах үйл ажиллагааг өргөжүүлэх, хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл, вэб сайтаар нийтэд мэдээлэх	2017.03.01-2017.12.30	2017.04.07	100%
7. Хийгдсэн аудит бүрээр судалгааны санг бүрдүүлж, баяжилт хийх	2017.01.01-2017.12.31	2017.04.01	50%

8.АГ-ын 2016 оны аудитын болон ажлын албан бичиг баримтыг архивлах	2017.01.10- 2017.12.31	2017.04.01	100%
9. өргөдөл санал хүсэлтийг бүртгэн авч шийдвэрлэх, хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах	2017.01.10- 2017.12.31		хийгдээгүй
10. Хийсэн аудит бүрийн дүнг УЗХ-р хэлэлцүүлэн баталгаажуулах	2017.02.25- 2017.12.31		Хэрэгжээгүй
11. аудит бүрийн дүнг шалгагдагч байгууллагад танилцуулах	2017.02.25- 2017.12.31	2017.04.14	50%

3. Гүйцэтгэлийн аудитын хэрэгжилт:

Байгууллагын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөнд

- УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу
 - Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг
 - Засгийн газраас олгосон векселийн үр дүнд хийх гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөгдсөн.

Эдгээр гүйцэтгэлийн аудитын зорилго, зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлт, арга зүйн асуудлын талаар аймгийн ИТХ, ЗДТГ-ын ХБХОТХэлтэс, ГХБХБГ, Өмчийн газрын дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан аудитын нээлт хийж аудитыг төлөвлөгөөт хугацаанд эхлэн хэрэгжүүлээ.



Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашгийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын талаар:

Архангай аймагт 2016 онд 367.7 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй 3 их засварын ажил, 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах 1 арга хэмжээ, он дамжин хэрэгжиж буй 1501.3 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 3 ажлыг холбогдох ТЕЗ нараас аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн санхүүжүүлж хэрэгжүүлжээ. Мөн Орон нутгийн авто

замын сангийн хөрөнгөөр 2016 онд он дамжин хэрэгжих 2 ажил, шинээр хэрэгжүүлэх 2 төсөл арга хэмжээг нийт 223.8 сая төгрөг, аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 4.1.24¹-д заасан тодорхойлолт нийцэх 2 арга хэмжээнд 57.5 сая төгрөгийг тус тус зарцуулсныг аудитаар шалгалаа.

Аудитаас Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилт удааширснаас ашиглалтанд орох хугацаа хойшилж, хүртэх үр дүн, үр ашиг хүлээгдсээр байна гэсэн дүгнэлтийг өглөө.

Аудитаар 2016 онд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр зураг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэрийг өөрчилж батлагдаагүй арга хэмжээнд зарцуулсан, хөрөнгө оруулалтын ажилд тавих шат шатны хяналт хангалтгүй, төсвийг оновчтой хуваарилж чадаагүйгээс улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй ашиглалтанд орох хугацаа хойшилсоор байгаа, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаанд батлагдсан төсөвт өртгийг хуваах замаар ХАА-г зохион байгуулсан зэрэг хууль зөрчсөн зөрчил дутагдлууд илэрсэнд аудитаас зөрчил дутагдлыг арилгах албан шаардлагыг хүргүүлж, ажиллалаа.

Орон нутагт эрх шилжүүлэх ажил хугацаа алдаж оны сүүлийн хагаст шилжүүлэгдсэн нь ТАХ-ний хэрэгжилт удаашрах, он дамжин хэрэгжих зэргээр чанарт сөргөөр нөлөөлж байгаа байдал ажиглагдаж байлаа.

Аудитаар нийт 154.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах үүднээс 7-н албан шаардлага хүргүүлж, цаашид хөрөнгө оруулалтын талаар анхаарвал зохих болон засаж сайжруулах чиглэлээр 9-н заалт бүхий зөвлөмж хүргүүлээд байна.



Засгийн газраас олгосон векселийн үр дүнд хийх гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөгдсөн.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 сарын 09-ны өдрийн хуульд Архангай аймагт 2016 онд 1316.8 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 9 ТАХ-г орон нутгийн ТЭЗ-д эрх шилжүүлэн, 8 ТАХ-г 1306.3 сая төгрөгөөр санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна.

¹ “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

Эдгээрээс Нийтийн номын сангийн барилгад их засвар хийх ажлын векселиэр санхүүжүүлсэн ТАХ-ний бодит гүйцэтгэл санхүүжилтийн нотлох баримт орон нутагт үзэгдэж бусад нь төрийн захиргааны төв байгууллагад байна.

Аудитаас дараах дүгнэлтийг өгч ажилласан.

1. Орон нутагт эрх шилжүүлж векселиэр хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилтийг хэрхэн тооцож олгосныг нотлох баримт, материалууд аймгийн холбогдох эрх бүхий байгууллагад алга байна.
2. Векселийн санхүүжилтийг орон нутгийн ТЕЗ-ийн дансаар дамжуулалгүй, захиалагчийн хяналтаар баталгаажуулахгүй гүйцэтгэгч нарт олгосон байна.
3. Векселиэр санхүүжүүлсэн зарим ТАХ-ний гүйцэтгэл дутуу, ашиглалтын явцад чанарын доголдол, эвдрэл гэмтэл гарч байгаа нь захиалагчийн хяналтаар баталгаажуулахгүй олгож үр дүнгүй зарцуулсан байна.

4. НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭРЭГЖИЛТ

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу

- *Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд*
- *Байгууллагын өөрийн төлөвлөгөөгөөр / он дамжсан /*
 - *Газрын тухай хуулийн хэрэгжилтэд тус тус нийцлийн аудитыг хийлээ.*



“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт” -д хийж байгаа нийцлийн аудит 2017 оны 3 дугаар сард төлөвлөгдсөн хугацаандаа эхэлж, аудитын нээлтийг аймгийн ИТХ, ЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ, Өмчийн газрын дарга, мэргэжилтнүүдэд танилцуулж, аймгийн бүх сумдад ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ны хэрэгжилтийг аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтний хамт газар дээр нь очиж шалган, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтыг баримтаар тулган шалгаж, аудитыг төлөвлөгдсөн хугацаанд нь хэрэгжүүлж, аудитын тайлан, дүгнэлт, санал зөвлөмжийг аймгийн Засаг дарга, ҮАГ–т хүргүүлээ.

2016 оны ОНХС-ийн аудитаар нийт **1,136.5** сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс **1.8** сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоож, **1134.7** сая төгрөгөнд албан шаардлага хүргүүлж хүргүүлж, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн засаг даргад хүргүүллээ.

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлаас дурьдахад сумдад ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудад мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хийлгэдэггүй, гэрээ дүгнэдэггүй, Худалдан авах ажиллагааны хуулийг мөрддөггүй, сумдын хувьд үнэлгээний хороонд ажиллаж байгаа гишүүд нь худалдан авах ажиллагааны сертификатгүй, мэргэжлийн бус, зарим гүйцэтгэсэн ажлын чанар муу зэрэг нийтлэг зөрчил дутагдлууд илэрсэн. Мөн зарим сумдад баригдсан барилга байгууламжийн ашиглалтын зардлыг шийдвэрлээгүйгээс шинээр баригдсан хөрөнгө ашиглагдахгүй байх, зарим сумдад хөтөлбөр арга хэмжээний нэрээр төсөв хөрөнгийг төлөвлөж байгаа хэдий ч хөрөнгийг урсгал зардалд зарцуулж байгаа байдал ч ажиглагдаж байна.

Эдгээр зөрчлүүд нь СС-ын 43-р тушаалаар батлагдсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай Монгол улсын хуулиудын холбогдох заалттуудтай нийцэхгүй байна.

Аудитаас дараах дүгнэлтийг хийлээ.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж, сумдад олгох шилжүүлэгийг бүрэн олгосон байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд захиалагчийн зүгээс бүрэн хяналт тавьж ажиллаж чадахгүй байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн байдалд хууль, журмын хүрээнд дотоод хяналт тавьж ажиллаагүй байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд хэвийн ашиглагдаж байгаа ч зарим ТАХ-ний урсгал зардлыг шийдвэрлэх шаардлагатай байна.



Аймгийн ИТХ-ын захиалгаар Газрын тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг хийж дараах дүгнэлтийг өгч ажиллалаа.

2015-2016 оны байдлаар Архангай аймгийн газар олголт төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан ч дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт нь холбогдох журмын зарим заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд газар өмчлөлийн хуулийн хэрэгжилт хангалтгүй, нийт иргэдийн 15.5% нь газраа өмчилж авсан байна.

Аймгийн хэмжээнд 2016-2016 онд газрын дуудлага худалдааны орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж, газрын төлбөрийн орлогыг нийт дүнгээр биелүүлсэн ч зарим сумдын хувьд тухайн орлогуудыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын 2017 оны төлөвлөгөөний 3.1, 3.2 –т тусгагдсан санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуулийн 8.9.1-8.9.3 дахь заалтын дагуу хуулийн цаглабарт заасан хугацаанд төсөв захирагчдын ангилал бүрээр бүрэн хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын журмын 2.4.2 дахь заалтын дагуу Монгол улсын Ерөнхий аудиторов тушаалаар санхүүгийн тайлангийн аудитын хуваарь батлагдсан. Үүний дагуу аймгийн Аудитын газрын дарга Тэргүүлэх аудиторовын 2016 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар аудитын хуваарь батлагдсан.

Аудитад аймгийн хэмжээнд Төсвийн тухай хуулийн хүрээнд нийт 214 төсөв захирагчдын тайлан хамрагдахаас 44 төсөв захирагчдын тайланд итгэл үзүүлж, 118 төсөв захирагчдийн тайланд аудитын дүгнэлт гарган 52 төсөв захирагчдын тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитаас Төсвийн шууд захирагчдын -93 тайлан, сумдын Засаг дарга нарын 19, Засгийн газрын тусгай сангийн 3, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2, ТЭЗ-гчийн-1 нийт 118 тайланд дүгнэлт хүргүүлсэн байна. Нийт

дүгнэлтийн 109 нь Зөрчилгүй, 9 тайлан Хязгаарлалттай дүгнэлт өгч 12 албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээ тооцуулах саналыг хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3012.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг өмнөх онтой харьцуулахад 2 дахин буурсан дүнтэй байна.

Аудитаас 104.6 сая төгрөгийн зөрчил дутагдалд 59-н төлбөрийн акт тогтоож, 1125.9 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгах 78-н албан шаардлагыг хүргүүлэн, 1654.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн, 128.3 сая төгрөгийг зөрчилтэй асуудлыг дараагийн шатны байгууллагад шилжүүлэн ажиллалаа.

➤ Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар :

2017 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 25-ны хооронд Аудитын газрын бүх аудитор шинжээчид 93-н төсвийн шууд захирагчийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайлангийн аудитад оролцож, аудитыг хугацаанд нь амжилттай хийж гүйцэтгэлээ. Аудитад нийт 4947 хүн өдөр зарцуулж, аудитын үйлчилгээний хөлсөөр 9.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан.

Аудитаар илэрсэн зөрчлийн дийлэнх хувийг шатахууны зарцуулалт тайлан гаргаагүй, жолоочийн тооцоо бодоог, орон нутгийн өмчийн албаны зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн, үдийн цай, хүүхдийн хоолны хүнсний материалыг их хэмжээгээр бэлтгэсэн зэрэг зөрчил эзэлж байна.

➤ Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

2017 оны 03 дугаар сарын 05-наас 25 ны хооронд Аудитын газрын Санхүүгийн багийн гишүүд аймгийн 19-н сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитыг хийж 17 –н тайланд зөрчилгүй, 2 тайланд Хязгаарлалттай дүгнэлтийг хүргүүлээд байна.

Сумдын нэгтгэсэн тайлангийн аудитаар сумын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелж байгаа хэдий ч нэр төрлийн хувьд биелээгүй, өмнөх зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгаад сумдын Засаг дарга нарт менежмент захидлаар дахин зөвлөмж хүргүүлээ.

➤ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

2017 оны 02 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 15-ны хооронд аймгийн АЗЗА ТӨХК, Ундарга орон нутгийн өмчит ХХК-ны жилийн эцсийн санхүүгийн

тайланд аудитаар АЗЗА ТӨХК –нд Зөрчилгүй, Ундарга орон нутгийн өмчит ХХК-нд Хязгаарлалттай дүгнэлтийг тус тус өгч ажиллалаа.

Ундарга орон нутгийн өмчит ХХК-ны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн илрүүлэлт асуудлын бүртгэлийг харилцагч байгууллагад албан тоотой танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг дурьдсан хугацаанд ирүүлээгүй, аудитаар илэрсэн илрүүлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, холбоотой нотлох баримтыг ирүүлээгүй тул 128.3 сая төгрөгийн илрүүлэлтийг нягтлан судалж ҮАГ –т уламжилан зөвлөгөө авсны дүнд Сангийн Яамны худалдан авах ажиллагааны газар болон Авилгатай тэмцэх газарт хүргүүлээд байна.

6 БУСАД АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2017 оны 1-р улиралд бусад ажил үйлчилгээний төлөвлөгөөгөөр нийт 12 ажил хийгдэхээс 10 ажил бүрэн хийгдэж, 7.12, 7.13 дахь ажлууд бүрэн хийгдээгүй байна.

Бүрэн хэрэгжсэн ажил бүрээр товч танилцуулвал:

- ❖ “Аймгийн Аудитын газрын мэргэжлийн тасралтгүй сургалтын 2017 оны хөтөлбөр, жилийн сургалтын төлөвлөгөө батлуулах ажлын хүрээнд байгууллагын ажилтнуудад зориулсан 2017 оны МТСургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан батлуулав.
- ❖ Байгууллагын ажилтнууд 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Тэргүүлэх аудитортой үр дүнгийн гэрээг 2017 оны 3 дугаарын 17-ны өдөр байгууллаа.
- ❖ Төрийн аудитын байгууллагын албан тушаалтны ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн 2017 оны 2 дугаар сарын 18-нд ҮАГ-т цахимаар хүргүүлээ.
- ❖ Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шилэн дансанд тухай бүр оруулах 8 төрлийн мэдээллийг 7 хоногийн дотор, сар бүр оруулах 3 төрлийн мэдээллийг дараа сарын 8-ны дотор оруулж 1-р улирлын байдлаар нийт мэдээлвэл зохих бүх мэдээллийг бүрэн оруулсан.
- ❖ ҮАГ-ын цахимт сайтанд 1-р улирлын байдлаар аудиттай холбоотой 9 мэдээлэл, ТЭЗ-гчийн харъяа орон нутгийн 26 төсөв захирагчдын санхүүгийн аудитын тайлангууд бүрэн байршуулж ажиллалаа.
- ❖ Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланг судалгаагаар нэгтгэж мэдээлэл санг баяжууллаа.

- ❖ Санхүүгийн тайлангийн аудитад СТАУС программыг бүрэн ашиглаж, аудитын үе шат бүрийн ажлын гүйцэтгэл уг программд 100% хийгдсэн байна.
- ❖ Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн аудитын шат шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа.
- ❖ Байгууллагын санхүүгийн 2016 оны баримтыг архивласан бөгөөд санхүүгийн тайланд Улаанбаатар-Аудит ХХК аудит хийж Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж 3 сарын 18-нд ҮАГ-т хүргүүлсэн.
- ❖ Өргөдөл, санал хүсэлтийг бүртгэн авч шийдвэрлэх, хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн ОБХ-ээс ирүүлсэн хүсэлтийн дагуу шалгалтыг хийж хариуг 2017.03.29-нд албан бичгээр хүргүүлж, Цэнхэр сумын ЕБС-ийн багш нарт өргөдлийн хариуг хүргүүллээ.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олон бид байгууллагын 2017 оны төлөвлөгөөт ажлаа амжилттай биелүүлэхийн тулд хичээн ажиллаж байна.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2017.05.04

